

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## Агуулга

1. Агуулга.....	1
1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	9
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	9
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	10
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	10
3. Менежментийн захидал.....	11
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	17

### Товчилсон үгийн жагсаалт

ҮАГ	Үндэсний аудитын газар
МУ	Монгол улс
САГ	Санхүүгийн аудитын газар
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ДҮТ	Диспетчерийн үндэсний төв
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ  
СИСТЕМ” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ Г.ОТГОНБААТАР  
ТАНАА

2020 03.13 № 06/816  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Г.Отгонбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн цахилгаан эрчим хүчний тарифын асуудал болон НБББББ, татварын өр төлбөртэй холбоотой зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон НББОУС, СТОУС түүнд нийцүүлэн гаргасан аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 28-наас 2020 оны 03 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 11-ний өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Бэст фортуна аудит” ХХК-ийн аудитын баг хариуцаж хэрэгжүүлэв.

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланг “Бэст фортуна аудит” ХХК-д 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 1/144 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Хэрэглэгчийн хэрэгцээт цахилгаан, дулааны эрчим хүчийг үйлдвэрлэн хэвийн найдвартай хангах явдал” юм.

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Цахилгаан, дулаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх,
- Цахилгаан импортлох,
- Эрчим хүчний тоноглолд засвар туршилт хийх,
- Цахилгаан эрчим хүч, дулааны эрчим хүчний тоолуур, гүйдлийн трансформатор суурилуулах, засварлах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль /нэмэлт өөрчлөлт/;
- Эрчим хүчний зохицуулах хорооны 2019 оны 181 тоот тогтоолоор баталсан “Тусгай зөвшөөрлийн харилцааг зохицуулах аж ахуйн харилцааны дүрэм”;
- Эрчим хүчний зохицуулах хорооны 2019 оны 522 тоот тогтоолоор баталсан “Эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглах түлшний үнийг тогтоох аргачлал”;
- Эрчим хүчний сайдын 2019 оны 196 тоот тушаалаар баталсан “Эрчим хүчний салбарын төрийн өмчит байгууллагын ажилтаны ёс зүйн дүрэм”.

## 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус байгууллагын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцээгүй байна.

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Veritech Accounting” онлайн програм хангамж ашигладаг байна.

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 10 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд 2018 оны Орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлаар суурь үзүүлэлтийг сонгон 44,055.4 сая төгрөгөөс тооцон 440.сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тодорхойлсон материаллаг байдлын суурь болон хувийг хэвээр авч 2019 оны Орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын дүнгээс 500.3 сая төгрөгөөр тооцсон нь зардал төлөвлөлтийн үеэс 13.6 хувиар өссөнтэй холбоотой болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,475.3 сая төгрөгөөр буюу 1.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал урьдчилж төлсөн тооцоо, үндсэн хөрөнгө, өр төлбөр, хойшлогдсон орлого, төрийн өмч, эздийн өмчийн бусад хэсэг, хуримтлагдсан ашиг гэх мэт данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/сая төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	41.0	142.8	101.8
Дансны авлага	18.1	65.9	47.8
Татварын авлага	1.8	0.9	(0.9)
Бусад авлага	22.1	451.4	429.3
Бараа материал	2,046.5	1,766.1	(280.4)
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1,014.5	33.0	(981.5)
Бусад эргэлтийн хөрөнгө	40.9	43.2	2.3
Үндсэн хөрөнгө	76,247.0	75,491.7	(755.2)
Биет бус хөрөнгө	18,413.2	18,374.8	(38.4)
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>97,845.1</b>	<b>96,369.8</b>	<b>(1,475.3)</b>
Дансны өглөг	3,174.9	2,612.9	(562.0)
Татварын өр	255.2	806.5	551.3
Урьдчилж орсон орлого	218.0	222.7	4.7
Урт хугацаат өр төлбөр	9,289.4	8,502.2	(787.2)
Хойшлогдсон орлого	5,021.8	4,775.6	(246.2)
<b>Өр төлбөрийн дүн</b>	<b>17,959.4</b>	<b>16,919.9</b>	<b>(1,039.5)</b>
Өмч: Төрийн	47,984.2	66,307.0	18,322.8
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	11,411.0	11,313.8	(97.2)
Эздийн өмчийн бусад хэсэг	18,322.8	95.3	(18,227.5)
Хуримтлагдсан ашиг	2,167.7	1,733.8	(433.8)
<b>Нийт өр төлбөр ба эздийн өмчийн дүн</b>	<b>97,845.1</b>	<b>96,369.8</b>	<b>(1,475.3)</b>

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 101.8 сая төгрөгөөр өссөн нь оны эцсээр цахилгааны төлбөрийн орлогын өсөлтөөс шалтгаалжээ.

Дансны авлага дансны үлдэгдэл 47.8 сая төгрөгөөр өссөн нь “Ганширээс” ХХК хэрэглэсэн цахилгаан эрчим хүчний төлбөр, алдангийн хамт 52.4 сая төгрөг төлөөгүйгээс шалтгаалжээ.

Бусад авлага 429.3 сая төгрөгөөр өссөн нь Петро Чайна Дачин Тамсаг ХХК-ийн 110 кВ-ын шугамын гэрээт ажлын чанарын барьцааны авлагаас голлон шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Авлагыг насжилтаар тооцож үзвэл:

/сая төгрөг/

Харилцагч	Нийт авлагын дүн	Авлагын насжилтын хугацаа					
		1-3 сар	4-6 сар	6-12 сар	1-3 жил	3-5 жил	5 жилээс дээш
Аж ахуйн нэгж байгууллагаас авах ЦДЭХ-ний авлага	53.6	53.6					
Айл өрхөөс авах ЦЭХ-ний авлага	5.2	5.2					
Байгууллагаас авах авлага	451.4	449.2		-		2.1	
Урьдчилж төлсөн тооцоо	33.0	26.5		6.5		0.0	
	<b>543.2</b>	<b>534.5</b>	<b>-</b>	<b>6.5</b>	<b>-</b>	<b>2.1</b>	<b>-</b>

Авлага дансны үлдэгдэлд 2017 онд үүссэн, “Тамир импекс” ХХК-аас авах 2.1 сая төгрөгийн дизель түлшний үнийн авлага байна. Гүйцэтгэсэн ажилд зориулж авсан түлшний үнийг төлөхгүй байгаа нь авлага найдваргүй болох эрсдэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 280.4 сая төгрөгөөр буурсан нь нүүрсний үлдэгдэл оны эхний үлдэгдлээс буурснаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд олон жил хадгалагдсан, ашиглалтгүй 18.3 сая төгрөгийн 45 нэр төрлийн бараа материал байна. Оны эцэст бараа материалын дансанд хэвийн хэмжээнээс илүү нөөц үүсээгүй байна.

Бараа материалын дансанд бүртгэлтэй 2019 онд худалдан авсан нүүрсний үнээс 1,031.8 сая төгрөгийн төлбөрийг нийлүүлэгч 2 байгууллагад санхүүгийн төлбөрийн чадварын байдлаас шалтгаалан шилжүүлээгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 755.2 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд 6,642.2 сая төгрөгөөр нэмэгдэж, 3,583.9 сая төгрөгийн хөрөнгийг ТӨБЗГ-ын 2019 оны 292 дугаар тогтоолоор актлаж данснаас хассан, хуримтлагдсан элэгдлийн дүн 3,813.5 сая төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ. МУ-ын Эрчим хүчний сайдын тушаалаар баталсан 2019 онд бараа, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөний дагуу 6,444.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг өөрийн хөрөнгөөр худалдан авсан, их засвар хийж капиталжуулсан байна. Мөн ТӨБЗГ-ын шийдвэрээр 178.6 сая төгрөгийн хөрөнгийг ЦДАШ-ыг балансаас балансад үнэ төлбөргүй шилжүүлэн авч бүртгэсэн байна.

Эрчим хүчний сайдын 2019 оны 45 дугаар тушаалаар 10,188.4 сая төгрөгийн “Бараа, ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөө” баталснаас нээлттэй тендер шалгаруулалтаар 32, харьцуулалтын аргаар 49, шууд худалдан авалтаар 27, шууд гэрээ байгуулалтаар 28, нийт 9,805.6 сая төгрөгийн 126 бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэн батлагдсан төсвөөс 382.8 сая төгрөгийг хэмнэсэн байна.

Тендер шалгаруулалтын талаар оролцогчид Сангийн яаманд 7 гомдол гаргасны 1 гомдол үндэслэлтэй гэж үзсэн мэдэгдлийн дагуу өмнөх шалгаруулалтыг цуцалж, тухайн худалдан авалтанд дахин тендер зарлаж шийдвэрлэсэн байна.

Биет бус хөрөнгийн оны эцсийн үлдэгдэл 38.4 сая төгрөгөөр буурсан нь 30.9 сая төгрөгийн программ хангамж, санхүүгийн бодлогын баримт бичиг хийлгэж бүртгэсэн, 69.3 сая төгрөгийн хорогдуулалт бүртгэсэнээс тус тус шалтгаалсан байна.



Өр төлбөр дансны үлдэгдэл 1,039.5 сая төгрөгөөр буурсан нь “Дорнод газар” ХХК-д төлсөн 867.9 сая, Германы сэргээн босголтын банкинд төлсөн 630.8 сая, Дэлхийн банкинд төлсөн 461.5 сая төгрөгийн урт хугацаат зээлийн төлөлтөөс шалтгаалжээ. Сэргээн босголтын банкнаас 2001 онд, Дэлхийн банкнаас 2009 онд тус тус дамжуулан зээлдүүлэх гэрээгээр, “Ди Би Эм лизинг” ХХК-аас авсан ажилчдын автобусны, нийт 8,502.2 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөр байна.

Нэмэгдсэн өртгийн албан татварын өр оны эцэст 551.3 сая төгрөгөөр нэмэгдэж үлдэгдэл 806.5 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

Үйлдвэрийн хуучин барилга, байгууламж, тоног төхөөрөмжийн их засварын ажилд зориулж худалдан авсан сэлбэг материал, ажлын хөлсөнд авсан НӨАТ-ын хасалт нь МУ-ын Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.1.15-д хамаарах эсэх талаар 2019 оны 12 дугаар сарын 25-ны 1/894 дугаартай албан бичгээр Татварын ерөнхий газарт асуулга тавьсны хариу 2020 оны 01 дүгээр сарын 03-нд 10/12 дугаартай албан бичгээр “14.1.5. үндсэн хөрөнгө бэлтгэхэд зориулж импортоор оруулсан буюу худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн болон үндсэн хөрөнгө худалдан авахад төлсөн албан татварыг хасахгүй” гэж заасан зохицуулалттай гэсэн хариуг ирүүлсэн байна.

Төрийн өмч дансны үлдэгдэл 66,307.0 сая төгрөг болж 18,322.8 сая төгрөгөөр өссөн нь Эздийн өмчийн бусад хэсэг дансанд өмнөх онд бүртгэсэн байгууллагын эзэмшлийн газруудын 18,227.5 сая төгрөгийг төрийн өмч дансанд шилжүүлэн бүртгэснээс шалтгаалжээ. Энэ нь сөрөг үр дагаваргүй болно.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга 25.6 сая төгрөгийн бичилт нь үндсэн хөрөнгийн элэгдлийн алдааны залруулгатай холбоотой байна.

## **2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д заасны дагуу хөрөнгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, удирдлага нь энэ хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасан аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрх, үүргийг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Эрчим хүчний сайдын 2019 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 19 тоот тушаалаар “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн нийт орлогыг 43,385.9 сая, нийт зардлыг 43,385.9 сая, ашгийг 0 төгрөгөөр тус тус баталсан.

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК нь тайлант онд 49,708.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны зардалд 50,095.6 сая төгрөгийг зарцуулж, 387.4 сая төгрөгийн алдагдалтай ажиллажээ. Орлого өмнөх оноос 4,506.2 сая төгрөгөөр, зардал 5,881.6 сая төгрөгөөр тус тус өссөн байна. Энэ нь үндсэн хөрөнгийн дахин үнэлгээнээс шалтгаалж элэгдлийн зардал нэмэгдсэн, цалингийн доод хэмжээ нэмэгдснээс шалтгаалан эрчим хүчний системд мөрдөх цалинг 10 дугаар сараас эхлэн нэмэгдүүлсэн, уул уурхайн компаниудад нийлүүлж байгаа цахилгаан эрчим хүчний тарифийг Эрчим хүчний зохицуулах хорооноос индексжүүлээгүй, Диспетчерийн үндэсний төвөөс худалдан авах цахилгааны тарифийг 2018 оны 11 дүгээр сараас нэмэгдүүлэн уул уурхайн компаниудад нийлүүлж байгаа тарифаас өндрөөр тогтоосон, диспетчерийн зохицуулалтын төлбөр, зохицуулалтын үйлчилгээний хөлс нэмэгдсэн, тусгай зөвшөөрлийн хугацааг 10 жилээр сунгуулсан, харуулын хаалга бүрэн сольсон, урьдчилж төлсөн зардлын дансанд үлдэгдэлтэй байсан цахилгааны шугамын зардлыг актыг үндэслэн өртөгт бүртгэсэн зэргээс голлон шалтгаалжээ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан зорилтот түвшний орлогын төлөвлөгөөг 7,784.4 сая төгрөг буюу 18.6 хувиар давуулан биелүүлж зардлыг 6,709.7 сая төгрөг буюу 15.5 хувиар илүү зарцуулжээ.

## 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 10 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 3 эрсдэл тодорхойлж нийт 10 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 5,051.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 1,125.0 сая төгрөгийн алдааг залруулж, 1,576.1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 2,350.4 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Аудитын явцад 1,125.0 сая төгрөгийн алдаа, зөрчлийг залруулсан болно. Үүнд:

- Тооллогоор дутагдсан материалын зөрүүг хэрхэн шийдвэрлэсэн тухай тооцоо актанд тодорхой дурьдаагүй, баримтжуулаагүй 10.8 сая төгрөг,
- Бэлэн мөнгөний кассын үлдэгдэл НБББББ-т хязгаарласан дээд хэмжээнээс хэтэрсэн 51.6 сая төгрөг,
- Цахилгаан эрчим хүчний шугамын барилга угсралтын ажлын зардлыг акт баталгаажүүлсэн зөвшөөрч бүртгээгүй 1,013.3 сая төгрөг,
- Тендер шалгаруулалын талаар Сангийн яаманд өргөдөл гаргасан 1 гомдол үндэслэлтэй байсан тул дахин шалгаруулалт явуулсан 49.4 сая төгрөг,
- О.Бат-Эрдэнийн сахилгын шийтгэлийн арга хэмжээний хугацаа дуусаагүй байхад сарын үр дүнгийн шагналт цалин олгосон 0.1 сая төгрөг.

### Шийдвэрлэсэн нь:

Завсрын аудитаар илэрсэн дээрх зөрчлүүдийг залруулах зөвлөмж өгөв.

Аудитаар дараах 3,926.5 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 1,576.1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

Эрчим хүчний зохицуулах хорооноос уул уурхайн компаниудад нийлүүлэх цахилгаан эрчим хүчний тарифыг 2015 оноос хойш индексжүүлээгүй, Диспетчерийн үндэсний төвөөс худалдан авах цахилгаан эрчим хүчний тарифийг өндрөөр тогтоосноос Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК нь тайлант онд алдагдалтай ажиллахад голлох нөлөө үзүүлсэн байна. Энэ нь Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5-д “эрчим хүчний хэрэглээг хамгийн бага өртгөөр хангах чадавхийг бүрдүүлсэн, зохих ашгийн түвшин бүхий үнэ, тарифын тогтолцоог бий болгох” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Шийдвэрлэсэн нь:

Эрчим хүчний зохицуулах хороонд албан шаардлага хүргүүлэх

Аудитаар илэрсэн 2,350.4 сая төгрөгийн алдаа, зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## 2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Эрчим хүчний зохицуулах хорооны 2019 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 56 тоот тогтоолоор Диспетчерийн үндэсний төвөөс худалдан авах цахилгааны кВт/ цагийн тарифийг 181.81 төгрөгөөр тогтоосон боловч уул уурхайн компаниудад нийлүүлж байгаа цахилгааны кВт/ цагийн тарифийг 2015 оноос хойш индексжүүлээгүй, дунджаар 155 төгрөгөөр мөрдүүлснээс 2019 онд төвийн бүсээс худалдан авсан 58.8 сая кВт цахилгаан эрчим хүчний үнийн тарифийн зөрүүгээс 1,576.1 сая төгрөгийн алдагдал хүлээсэн тул тарифийн асуудлыг дээд шатны байгууллага хэрхэн шийдвэрлэснийг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй.

## 2.12. Шилэн дансны мэдээлэл

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын мэдээлэл, бусад 36 мэдээллийг

хугацаанд нь тухай бүр оруулсан байна. Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

### **2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

1. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 4.8 сая төгрөгийн төлбөрийн актыг бүрэн барагдуулсан,

2. “Диспетчерийн үндэсний төв” ХХК-аас худалдан авах цахилгааны тарифийг 230.9 төг/кВт.цагаар тогтоосноос 1,293.0 сая төгрөгөөр зардал өссөн зөрчлийг арилгах Албан шаардлага Эрчим хүчний зохицуулах хороонд хүргүүлсэн. ДҮТ-ээс худалдан авах цахилгаан эрчим хүчний тарифийг 2019 оны 1 дүгээр сараас 181.81 төгрөгөөр тогтоосон байна.

3. Менежментийн захидлаар өгөгдсөн 1 зөвлөмж хэрэгжсэн.

### **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

#### **“Зөрчилгүй” дүгнэлт**

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, НББОУС, СТОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.1 дэх заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### 3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 3.1 Зардлын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт: 2018 оны 11, 12 дугаар саруудад ашиг бууруулах зорилгоор ДҮТ-ээс худалдан авах цахилгаан эрчим хүчний тарифийг 2.3 дахин нэмэгдүүлснээс ашиг буурч 2018 онд 895.1 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан. Ашиг буурсан нь тухайн байгууллагын үйл ажиллагаанаас хамаараагүй гэж үзэн ТУЗ-өөс 2018 оны жилийн үр дүнгийн шагналыг 4 сараар олгох шийдвэр гаргаж 2019 оны 1 дүгээр сард 1,543.9 сая төгрөг олгож тайлант оны үр дүнд нөлөөлсөн нь Сайнхүүгийн тайлангийн “Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл: Зардал гаргах эх үүсвэр дутагдах, тайлант хугацааны үр дүнд сөргөөр нөлөөлөх

3.1.3 Өгсөн зөвлөмж: Цахилгаан эрчим хүчний тарифийн асуудлуудыг дээд шатны байгууллагад дахин тавьж шийдвэрүүлэх

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Тарифийн асуудлаар дээд шатны байгууллагад дахин хандана

#### 3.2 Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

3.2.1 Илрүүлэлт: Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК-нд ашиглагдаж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь байгууллагын үйл ажиллагааны онцлогтой бүрэн уялдаагүй, шинэчилсэн хууль, заавар, журмын өөрчлөлттэй нийцээгүй, үндсэн хөрөнгө бэлтгэх, их засвар хийж капиталжуулах, бүртгэх, худалдан авах ажиллагааны журмууд тусгагдаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалт, санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдэлтэй тус тус нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл: Нягтлан бодох бүртгэлд алдаа гарах, шаардлагатай журмуудыг боловсруулж мөрдөөгүйгээс хөрөнгө үрэгдэх

3.2.3 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг байгууллагын үйл ажиллагааны онцлог, шинэчлэгдсэн хууль, заавар, журмын шаардлагад нийцүүлэн шинэчлэн боловсруулж мөрдөх

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: шинэчлэхээр төлөвлөж байна

### **3.3 Татварын өр төлбөр**

3.3.1 Илрүүлэлт Тайлант оны эцэст НӨАТ-ын 806.5 сая төгрөгийн өртэй гарсан нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 “Албан татвар суутган төлөгч нь борлуулсан бараа, ажил үйлчилгээнд ноогдох албан татварыг дараа сарын 10-ны өдрийн дотор төрийн сангийн нэгдсэн дансанд шилжүүлж баталсан маягтын дагуу тайлангаа харъяалах татварын албанд тушаана”, Зөрчлийн тухай хуулийн 11 дүгээр бүлгийн 11.19 Татварыг хуулиар тогтоосон хугацаанд төлөөгүй бол хүн, хуулийн этгээдийг хугацаа хэтэрсэн хоног тутамд төлөгдөөгүй татварын 0.1 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” заалтуудтай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.3.2 Эрсдэл: Татварын өрийг хугацаанд нь төлөөгүйгээс алданги, торгууль төлөх эрсдэлтэй

3.3.3 Өгсөн зөвлөмж: Татварын өр төлбөрийг хугацаанд нь төлж барагдуулж байх, зөрчлийг давтахгүй байх

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

- Татварын ерөнхий газраас “Бусдаар гүйцэтгүүлсэн их засварын ажлын хөлс, сэлбэг, материалын НӨАТ-ыг хасахгүй, капиталжуулна гэсэн хариу ирүүлсэн,
- Санхүүгийн төлбөрийн чадвар суларсан зэргээс шалтгаалан өр төлбөрийг хугацаанд нь төлөөгүй бөгөөд хойшид зөвлөмжийг хэрэгжүүлнэ.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дүгээр сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүү байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
			/төгрөгөөр/
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	41,033,633.05	142,806,161.85
1.1.2	Дансны авлага	18,068,294.71	65,876,877.92
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	1,767,263.86	890,783.55
1.1.4	Бусад авлага	22,093,981.26	451,399,679.38
1.1.6	Бараа материал	2,046,484,777.58	1,766,070,598.23
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1,014,548,554.22	32,983,098.98
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	40,935,052.30	43,193,000.00
1.1.10			
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b><u>3,184,931,556.98</u></b>	<b><u>2,503,220,199.91</u></b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	76,246,959,216.65	75,491,748,577.68
1.2.2	Биет бус хөрөнгө	18,413,164,142.61	18,374,802,921.31
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b><u>94,660,123,359.26</u></b>	<b><u>93,866,551,498.99</u></b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>97,845,054,916.24</u></b>	<b><u>96,369,771,698.90</u></b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	3,174,916,283.06	2,612,873,568.44
2.1.1.3	Татварын өр	255,207,652.47	806,499,281.88
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	217,998,175.00	222,673,157.76
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b><u>3,648,122,110.53</u></b>	<b><u>3,642,046,008.08</u></b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл	9,289,415,109.01	8,502,201,890.19
2.1.2.5	Хойшлогдсон орлого	5,021,835,243.41	4,775,616,039.61
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b><u>14,311,250,352.42</u></b>	<b><u>13,277,817,929.80</u></b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b><u>17,959,372,462.95</u></b>	<b><u>16,919,863,937.88</u></b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч: - төрийн	47,984,200,655.36	66,306,982,543.66
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	11,411,034,495.96	11,313,831,331.75
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	18,322,781,888.30	95,273,683.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	2,167,665,413.67	1,733,820,202.61
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b><u>79,885,682,453.29</u></b>	<b><u>79,449,907,761.02</u></b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>97,845,054,916.24</u></b>	<b><u>96,369,771,698.90</u></b>

## 4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>41,622,779,534.94</b>	<b>47,537,200,081.69</b>
2	Борлуулалтын өртөг	29,073,750,307.97	35,723,163,195.63
<b>3</b>	<b>Нийт ашиг( алдагдал)</b>	<b>12,549,029,226.97</b>	<b>11,814,036,886.06</b>
4	Түрээсийн орлого	37,568,581.82	38,426,599.99
5	Хүүний орлого	159,142,146.87	35,473,519.91
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	3,482,567,687.65	2,097,159,737.23
9	Борлуулалт, маркетингийн зардал	8,899,064,165.01	9,693,434,627.19
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,697,233,335.07	1,912,206,887.25
11	Санхүүгийн зардал	95,402,889.44	89,972,259.75
12	Бусад зардал	4,289,967,648.05	2,613,431,519.13
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	58,648,240.73)	(63,418,459.91)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг ( алдагдал)		
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)</b>	<b>1,087,991,365.01</b>	<b>(387,367,010.04)</b>
19	Орлогын татварын зардал	192,858,351.26	34,989,465.57
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>895,133,013.75</b>	<b>(422,356,475.61)</b>
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)	895,133,013.75	(422,356,475.61)
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютынхөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
<b>24</b>	<b>Орлогын нийт дүн</b>	<b>895,133,013.75</b>	<b>(422,356,475.61)</b>



### 4.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	<b>2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>47,984,200,655.36</b>	<b>1,235,386,147.33</b>		<b>1,665,180,749.92</b>	<b>50,884,767,552.61</b>
2	НБББ-ын бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
3	<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>47,984,200,655.36</b>	<b>1,235,386,147.33</b>	-	<b>1,665,180,749.92</b>	<b>50,884,767,552.61</b>
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				895,133,013.75	895,133,013.75
5	Бусад дэлгэрэнгүй орлого					-
6	Өмчид гарсан өөрчлөлт		10,193,488,516.22	18,322,781,888.30		28,516,270,404.52
7	Зарласан ногдол ашиг				(392,648,350.00)	(392,648,350.00)
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(17,840,167.59)			(17,840,167.59)
9	<b>2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>47,984,200,655.36</b>	<b>11,411,034,495.96</b>	<b>18,322,781,888.30</b>	<b>2,167,665,413.67</b>	<b>79,885,682,453.29</b>
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				25,578,052.40	25,578,052.40
11	<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>47,984,200,655.36</b>	<b>11,411,034,495.96</b>	<b>18,322,781,888.30</b>	<b>2,193,243,466.07</b>	<b>79,911,260,505.69</b>
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(422,356,475.61)	(422,356,475.61)
13	Бусад дэлгэрэнгүй орлого					-
14	Өмчид гарсан өөрчлөлт	18,322,781,888.30		(18,227,508,205.30)		95,273,683.00
15	Зарласан ногдол ашиг				(134,269,952.06)	(134,269,952.06)
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(97,203,164.21)		97,203,164.21	-
17	<b>2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>66,306,982,543.66</b>	<b>11,313,831,331.75</b>	<b>95,273,683.00</b>	<b>1,733,820,202.61</b>	<b>79,449,907,761.02</b>



#### 4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	<b>45,633,272,304.69</b>	<b>52,719,933,572.17</b>
1.2	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	45,163,888,343.65	51,644,269,057.28
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	161,163,648.00	103,990,295.00
	Бусад мөнгөн орлого	308,220,313.04	971,674,219.89
	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>36,970,404,720.99</b>	<b>46,311,015,790.18</b>
	Ажиллагчдад төлсөн	10,368,234,389.74	12,160,132,137.77
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	3,003,784,137.14	3,613,502,419.92
	Бараа материал худалдан авахад төлсөн	9,212,219,493.83	15,155,438,585.94
	Ашиглалтын зардалд төлсөн	268,535,499.51	52,134,939.47
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	8,448,653,166.23	9,190,120,792.84
	Хүүний төлбөрт төлсөн	95,402,889.44	89,955,088.55
	Татварын байгууллагад төлсөн	4,161,996,280.78	3,602,732,434.27
	Даатгалын төлбөрт төлсөн	199,973,190.00	160,888,094.00
	Бусад мөнгөн зарлага	1,211,605,674.32	2,286,111,297.42
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>8,662,867,583.70</b>	<b>6,408,917,781.99</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	<b>3,333,237,580.84</b>	<b>1,057,070,546.61</b>
2.2	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	11,008,826.00	55,988,923.88
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	3,163,086,607.97	965,608,102.82
	Хүлээн авсан хүүний орлого	159,142,146.87	35,473,519.91
	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>13,898,697,208.11</b>	<b>6,474,925,771.15</b>
2.3	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	10,383,789,169.75	6,443,975,771.15
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	29,911,000.00	30,950,000.00
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	3,484,997,038.36	
	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(10,565,459,627.27)</b>	<b>(5,417,855,224.54)</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	<b>16,938,978.23</b>	<b>32,193,142.23</b>
3.2	Валютын ханшийн ашиг	16,938,978.23	32,193,142.23
	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>870,266,961.38</b>	<b>921,483,170.88</b>
3.3	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	430,910,848.32	766,618,295.22
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	46,707,763.06	20,594,923.60
	Төлсөн ногдол ашиг	392,648,350.00	134,269,952.06
	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(853,327,983.15)</b>	<b>(889,290,028.65)</b>
<b>5</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(2,755,920,026.72)</b>	<b>101,772,528.80</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>2,796,953,659.77</b>	<b>41,033,633.05</b>
<b>7</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>41,033,633.05</b>	<b>142,806,161.85</b>

**5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо:	Аудитын нэр:	<i>Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит</i>	Аудитын код:
2019/12/31			САГ-2020/4/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Байгууллага тайланд онд алдагдалтай ажиллахад Уул уурхайн компаниудад нийлүүлэх цахилгаан эрчим хүчний тариф, ДҮТ-ээс худалдан авах цахилгаан эрчим хүчний тарифийн зөрүү нөлөөлсөн	1,576.1	Албан шаардлага өгөх	Эрчим хүчний зохицуулах хорооны дарга	А.Тлейхан
2	2018 оны 11, 12 дугаар саруудад ашиг бууруулах зорилгоор цахилгаан эрчим хүчний тарифийг 2.3 дахин нэмэгдүүлснээс ашиг буурч 2018 онд 895.1 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан. Ашиг буурсан нь тухайн байгууллагын үйл ажиллагаанаас хамаараагүй гэж үзэн ТУЗ-өөс 2018 оны жилийн үр дүнгийн шагналыг 4 сараар олгох шийдвэр гаргаж 2019 оны 1 дүгээр сард олгосон нь тайлант оны үр дүнд нөлөөлсөн	1,543.9	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч	Г.Отгонбаатар Д.Гэрэлчулуун
3	НБББББ нь байгууллагын үйл ажиллагааны онцлогтой бүрэн уялдаагүй, шинэчилсэн хууль, заавар, журмын өөрчлөлттэй нийцээгүй, үндсэн хөрөнгө бэлтгэх, их засвар хийж капиталжуулах, бүртгэх, худалдан авах ажиллагааны журмууд тусгагдаагүй	0	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч	Г.Отгонбаатар Д.Гэрэлчулуун
	<b>Дүн</b>	<b>3,120.0</b>			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 02

№ 02/144

Улаанбаатар хот

СМ - 0020/4 /СТА-ТӨЧГ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Дорнод бүсийн эрчим хүчний систем" ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрчим хүчний зохицуулах хорооны 2019 оны 01 дүгээр сарын 31-ний 56 тоот тогтоолоор "Дорнод бүсийн эрчим хүчний систем" ТӨХК-д Диспетчерийн үндэсний төвөөс худалдан авах цахилгааны кВт/ цагийн тарифийг 181.81 төгрөгөөр тогтоосон боловч уул уурхайн компаниудад нийлүүлж байгаа цахилгааны кВт/цагийн тарифийг 2015 оноос хойш индексжүүлээгүй, дунджаар 155 төгрөгөөр мөрдүүлснээс 2019 онд төвийн бүсээс худалдан авсан 58.8 сая кВт цахилгаан эрчим хүчний үнийн тарифийн зөрүүгээс 1,576.1 сая төгрөгийн алдагдал хүлээсэн нь Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5-д "эрчим хүчний хэрэглээг хамгийн бага өртгөөр хангах чадвархийг бүрдүүлсэн, зохих ашгийн түвшин бүхий үнэ, тарифын тогтолцоог бий болгох" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т заасан "аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах акт тавих, зөрчлийг арилгах албан шаардлага өгөх...", Монгол улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д "...дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. "Диспетчерийн үндэсний төв"-өөс "Дорнод бүсийн эрчим хүчний систем" ТӨХК-д худалдах цахилгааны тарифыг үндэслэлтэй тогтоох,
2. "Дорнод бүсийн эрчим хүчний систем" ТӨХК-иас уул уурхайн олборлох, боловсруулах компаниудад худалдах цахилгааны үнийг индексжүүлэх асуудлыг шийдвэрлэх
3. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 06 дүгээр сарын 10-ны дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эрчим хүчний зохицуулах хорооны дарга А.Тлейханд хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ:

**ТОГТООСОН:**  
 САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
 БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
 Ц.НАРАНЧИМЭГ  
 АУДИТЫН МЕНЕЖЕР  
 Ц.ХОСЖАРГАЛ  
 "БЭСТ ФОРТУНА АУДИТ" ХХК-ИЙН  
 ЗАХИРАЛ Ж.ОЮУНЦЭЦЭГ  
 19120396

**ЗӨВШӨӨРСӨН:**  
 ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
 ДАРГА А.ТЛЕЙХАН  
 "ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ  
 СИСТЕМ" ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
 ЗАХИРАЛ Г.ОТГОНБААТАР  
 ЕРӨНХИЙ НЯГТДАН БОДОГЧ  
 Д.ГЭРЭЛЧУЛУУН

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

